



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ХӨДӨӨ АЖ АХУЙН ИХ СУРГУУЛИЙН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/15/НА-СТА-ТӨА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор
Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Б.Сэржмядаг
Утас: 261628 Цахим хаяг: serjmyadagb@audit.gov.mn
Ахлах аудитор: Ц.Энхжаргал
Утас: 261628 Цахим хаяг: enkhjargalts@audit.gov.mn
Аудитор: Ж.Энхтуяа
Утас: 261740 Цахим хаяг: enkhtuyaj@audit.gov.mn

Улаанбаатар хот
2022 он

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, гүйцэтгэл	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
3. Аудитын тайлан.....	11
3.1 Ерөнхий зүйл.....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Материаллаг байдал	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	13
3.6 Зорилтот түвшний төлөвлөлт, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	15
3.8 Аудитын гол асуудал	15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	16
3.10 Завсрын аудитын үр дүн, Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	17
4. Аудитын илрүүлэлт	17
4.1 Залруулсан алдаа	17
4.3 Албан шаардлага	17
4.4 Зөвлөмж.....	18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	20

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БШУС	Боловсрол шинжлэх ухааны сайд
БШУЯ	Боловсрол шинжлэх ухааны яам
БЗС	Боловсролын зээлийн сан
ҮАГ	Үндэсний аудитын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ШУТС	Шинжлэх ухаан технологийн сан
ХХААХҮЯ	Хүнс хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрийн яам
ХААИС	Хөдөө аж ахуйн их сургууль



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ХӨДӨӨ АЖ АХУЙН ИХ СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Т.ХЭРҮҮГА ТАНАА

2022.03.15 № 07/569
танай _____-ны № _____-т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1 Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Хөдөө аж ахуйн их сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Хөдөө аж ахуйн их сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 680.3 сая төгрөгийн алдаа зөрчил илэрч тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан нь дангаараа буюу эсвэл нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй, санхүүгийн тайлангийн "тохиолдсон байх", "үнэн зөв байдал", "толилуулга ба тодруулга", "эрх ба үүрэг" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд байгууллагын удирдлагын хүлээх үүрэг, хариуцлага

Байгууллагын удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/			
Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	5,584,867,895.17	4,725,173,178.29
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	889,315,376.99	132,139,415.21
31100	Кассад байгаа бэлэн мөнгө	15,010,599.00	423,445.63
31110	Төгрөг	15,010,599.00	423,445.63
31120	Гадаад валют	0.00	0.00
31130	Нэмэлт санхүүжилт	0.00	0.00
31140	Касс арилжааны банк	0.00	0.00
31200	Банканд байгаа бэлэн мөнгө	874,304,777.99	131,715,969.58
31210	Төгрөг	874,304,777.99	131,715,969.58
31213	Арилжааны банк дахь харилцах	874,304,777.99	131,715,969.58
33	АВЛАГА	2,119,502,379.75	1,339,973,798.71
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	133,679,999.17	75,115,095.05
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	448,088,426.30	398,638,993.00
33401	Дансны авлага /ТӨҮГ/	886,120,917.65	0.00
33402	Татвар, НДШ-ын авлага /ТӨҮГ/	0.00	0.00
33500	Бусад авлага	651,613,036.63	866,219,710.66
33510	Байгууллагаас авах авлага	184,034,688.63	398,641,362.66
33520	Хувь хүмүүсээс авах авлага	467,578,348.00	467,578,348.00
34	УРЬДЧИЛГАА	122,690,912.61	726,155,047.07
34600	Урьдчилж гарсан зардал		614,190,730.10
34710	Урьдчилгаа тооцоо	122,690,912.61	111,964,316.97
34711	Бараа материал бэлтгэх урьдчилгаа	26,248,607.24	71,000,866.47
34712	Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	0.00	0.00
34713	Цалингийн урьдчилгаа	44,821,352.27	36,048,450.50
34714	Томилолтын урьдчилгаа	51,620,953.10	4,915,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	2,453,359,225.82	2,526,904,917.30
35200	Дуусаагүй үйлдвэрлэл	161,012,860.06	140,833,986.06
35300	Бэлэн бүтээгдэхүүн	240,000.00	201,342,678.08
35400	Хангамжийн материал	2,234,360,865.85	2,122,633,059.83
35410	Бичиг хэргийн материал	40,484,451.66	13,721,557.30
35420	Аж ахуйн материал	2,076,788,607.99	1,897,423,925.40
35430	Сэлбэг хэрэгсэл	6,528,500.00	34,062,080.00
35440	Түлш, шатах тослох материал	15,364,529.40	35,091,445.33
35450	Барилгын засварын материал	17,872,776.80	64,572,051.80
35460	Хүнсний материал	77,322,000.00	77,762,000.00
35600	Мал амьтад	57,745,499.91	62,095,193.33
36	НӨӨЦИЙН БАРАА	0.00	0.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	45,139,677,753.04	43,909,037,552.47
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	45,139,677,753.04	43,909,037,552.47
39200	Биет хөрөнгө	23,973,858,931.34	22,758,179,950.99
39201	Барилга, байгууламж, орон сууц	19,591,334,739.16	19,639,018,689.16
39202	Хуримтлагдсан элэгдэл	(3,242,490,067.84)	(4,066,405,536.96)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	1,259,929,373.92	1,304,929,373.92
39204	Хуримтлагдсан элэгдэл	(756,875,316.02)	(845,329,286.55)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	11,169,774,972.37	11,914,562,434.87
39206	Хуримтлагдсан элэгдэл	(7,115,617,580.32)	(8,422,013,689.49)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	2,359,080,191.85	2,524,773,729.84
39208	Хуримтлагдсан элэгдэл	(1,779,331,422.26)	(1,946,684,845.28)
39216	Дуусаагүй барилга, байгууламж	1,571,962,351.00	1,666,256,492.00
39217	Ном	916,091,689.48	989,072,589.48

39300	Биет бус хөрөнгө	21,165,818,821.70	21,150,857,601.48
39301	Программ хангамж	191,217,500.00	191,217,500.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(121,006,008.30)	(133,365,508.52)
39303	Бусад биет бус хөрөнгө	21,116,204,280.00	21,116,204,280.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(20,596,950.00)	(23,198,670.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	50,724,545,648.21	48,634,210,730.76
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,534,220,585.37	593,902,419.32
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,534,220,585.37	593,902,419.32
41300	Өглөг	358,057,588.37	411,811,633.32
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	179,579,757.51	42,379,622.67
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	175,362,918.80	368,947,255.80
41360	Бусад өглөг	3,114,912.06	484,754.85
41361	Байгууллагад төлөх өглөг	3,114,912.06	484,754.85
41400	Урьдчилж орсон орлого	1,176,162,997.00	182,090,786.00
41420	Төлбөртэй ажил үйлчилгээний урьдчилж орсон орлого	1,127,278,472.00	182,090,786.00
41440	Бусад урьдчилж орсон орлого	48,884,525.00	0.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	49,190,325,062.84	48,040,308,311.44
51	Засгийн газрын хувь оролцоо	49,190,325,062.84	48,040,308,311.44
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	30,693,402,992.77	30,693,402,992.77
51200	Хуримтлагдсан үр дүн	3,914,752,496.93	2,764,735,745.53
51210	Өмнөх үеийн үр дүн	2,697,416,065.11	3,914,752,496.93
51220	Тайлант үеийн үр дүн	1,217,336,431.82	(1,150,016,751.40)
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс	0.00	0.00
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	14,582,169,573.14	14,582,169,573.14
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	50,724,545,648.21	48,634,210,730.76

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	21,937,602,111.68	20,975,318,509.93
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	21,220,482,166.48	18,851,547,966.28
120	Нийтлэг татварын бус орлого	21,207,161,166.48	18,844,041,085.48
120002	Хүүгийн орлого	43,837,157.66	2,360,219.89
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	20,352,044,016.27	18,831,286,314.59
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	13,432,817,930.94	13,995,949,028.40
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,598,575,658.38	2,577,868,107.30
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	2,097,142,119.15	1,522,682,165.37
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	223,508,307.80	734,787,013.52
120005	Түрээсийн орлого	5,015,400.00	10,030,000.00
120009	Бусад орлого	806,264,592.55	364,551.00
122	Тусламжийн орлого	13,321,000.00	7,506,880.80
122001	Хандив тусламж /дотоод/	13,321,000.00	7,506,880.80
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	717,119,945.20	2,123,770,543.65
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	717,119,945.20	2,123,770,543.65
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	717,119,945.20	2,123,770,543.65
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	20,712,384,234.31	22,108,031,381.86
21	УРСГАЛ ЗАРДАЛ	20,712,384,234.31	22,108,031,381.86
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	20,238,688,372.17	21,603,821,765.09
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	11,714,119,248.50	12,143,171,584.30
210101	Үндсэн цалин	8,095,577,445.11	8,279,546,292.55
210102	Нэмэгдэл	3,135,672,112.63	3,373,834,870.67
210103	Унаа хоолны хөнгөлөлт	482,869,690.76	489,790,421.08
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,491,387,205.24	1,427,481,577.95
210201	Тэтгэврийн даатгал	1,423,575,333.16	1,355,729,635.27
210205	Эрүүл мэндийн даатгал	67,811,872.08	71,751,942.68
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	847,981,056.49	1,045,051,352.59
210301	Гэрэл, цахилгаан	342,630,202.20	391,287,366.47
210302	Түлш, халаалт	219,024,533.30	322,668,164.12
210303	Цэвэр, бохир ус	286,326,320.99	331,095,822.00
2104	Хангамж, бараа материалын зардал	286,086,269.63	561,100,595.62
210401	Бичиг хэрэг	51,584,850.25	100,757,644.00
210402	Тээвэр, шатахуун	34,666,109.05	18,488,731.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	98,050,678.54	94,621,674.52
210404	Ном, хэвлэл	12,634,000.00	11,922,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	33,492,100.00	39,682,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	13,462,731.15	236,978,637.10
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	42,195,800.64	58,649,409.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	257,430,556.01	414,825,734.12
210601	Багаж, техник, хэрэгсэл	18,288,345.13	15,387,191.00

210602	Тавилга	0.00	0.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	18,248,583.84	29,525,863.26
210604	Урсгал засвар	220,893,627.04	369,912,679.86
2107	Томилолт, зочны зардал	41,073,496.68	52,613,981.00
210701	Гадаад албан томилолт	9,781,963.68	8,822,404.00
210702	Дотоод албан томилолт	21,763,168.00	33,742,555.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	9,528,365.00	10,049,022.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	220,641,889.03	328,748,108.91
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	85,599,862.22	37,806,326.11
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	30,000,000.00	30,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	11,902,530.00	12,472,400.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	59,639,175.00	35,855,678.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	2,233,750.81	864,203.00
210813	Бусад зардал /ТӨҮГ/	31,266,571.00	211,749,501.80
210814	Орлогын татварын зардал /ТӨҮГ/	0.00	0.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,379,968,650.59	5,630,828,830.60
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,940,553,083.53	2,719,352,043.51
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	455,619,700.54	510,396,595.03
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	2,983,795,866.52	2,401,080,192.06
211	ХҮҮ	253,246,630.14	234,493,474.77
2112	Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр	253,246,630.14	234,493,474.77
211201	Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр	253,246,630.14	234,493,474.77
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	220,449,232.00	269,716,142.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	220,449,232.00	269,716,142.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	169,439,948.00	206,625,172.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	51,009,284.00	63,090,970.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	1,225,217,877.37	-1,132,712,871.93
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	11,332,135.67	285,559.14
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	11,332,135.67	285,559.14
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	19,213,581.22	17,589,438.61
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	2,960,481.07	0.00
225004	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	16,253,100.15	17,589,438.61
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	1,217,336,431.82	-1,150,016,751.40

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар б

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31- нээрх үлдэгдэл	30,693,402,992.77	14,582,169,573.14	2,697,416,065.43	47,972,988,631.34
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	-0.32	-0.32
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	30,693,402,992.77	14,582,169,573.14	2,697,416,065.11	47,972,988,631.02
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	1,217,336,431.82	1,217,336,431.82
10	2020 оны 12-р сарын 31- нээрх үлдэгдэл	30,693,402,992.77	14,582,169,573.14	3,914,752,496.93	49,190,325,062.84
11	2021 оны 1-р сарын 1- нээрх үлдэгдэл	30,693,402,992.77	14,582,169,573.14	3,914,752,496.93	49,190,325,062.84
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	30,693,402,992.77	14,582,169,573.14	3,914,752,496.93	49,190,325,062.84
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-1,150,016,751.40	-1,150,016,751.40
20	2021 оны 12-р сарын 31- наарх үлдэгдэл	30,693,402,992.77	14,582,169,573.14	2,764,735,745.53	48,040,308,311.44

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	17,716,653,735.51	19,198,802,535.24
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	16,999,533,790.31	17,075,031,991.59
120	Нийтлэг татварын бус орлого	16,985,678,087.81	17,067,150,110.79
120001	Хувьцааны ногдол ашиг	0.00	0.00
120002	Хүүгийн орлого	43,837,157.66	2,448,603.15
120003	Торгуулийн орлого	0.00	0.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	16,817,149,003.15	16,954,877,710.64
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	12,174,804,143.92	13,030,721,750.90
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,473,254,763.08	2,395,591,794.37
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	2,169,090,096.15	1,528,564,165.37
120005	Түрээсийн орлого	5,015,400.00	12,982,000.00
120009	Бусад орлого	119,676,527.00	96,841,797.00
122	Тусламжийн орлого	13,855,702.50	7,881,880.80
122001	Хандив тусламж /дотоод/	13,855,702.50	7,881,880.80
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	717,119,945.20	2,123,770,543.65
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	717,119,945.20	2,123,770,543.65
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	717,119,945.20	2,123,770,543.65
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	17,003,336,398.47	19,645,642,098.03
21	УРСГАЛ ЗАРДАЛ	17,003,336,398.47	19,645,642,098.03
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	16,746,138,768.47	19,313,843,443.49
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	11,217,224,074.97	11,904,501,502.72
210101	Үндсэн цалин	11,217,224,074.97	11,904,501,502.72
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	619,752,520.52	1,378,856,415.64
210201	Тэтгэврийн даатгал	619,752,520.52	1,378,856,415.64
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	849,495,882.49	986,951,575.85
210301	Гэрэл, цахилгаан	344,094,028.20	332,033,570.73
210302	Түлш, халаалт	219,075,533.30	322,456,183.12
210303	Цэвэр, бохир ус	286,326,320.99	332,461,822.00
2104	Хангамж, бараа материалын зардал	359,609,310.54	412,509,762.73
210401	Бичиг хэрэг	48,105,480.00	58,006,096.00
210402	Тээвэр, шатахуун	56,143,665.00	43,385,251.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	90,449,578.54	93,737,845.73
210404	Ном, хэвлэл	0.00	19,878,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	32,537,000.00	69,425,377.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	54,817,369.00	38,205,785.00
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө /ТӨҮГ/	38,980,125.00	41,938,600.00
210410	Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ/	38,576,093.00	47,932,608.00
2105	Нормативт зардал	17,076,310.00	25,498,258.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	17,076,310.00	25,498,258.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	221,164,332.00	576,250,377.44

210601	Багаж, техник, хэрэгсэл	20,915,098.00	28,018,660.00
210604	Урсгал засвар	200,249,234.00	548,231,717.44
2107	Томилолт, зочны зардал	42,780,001.68	41,162,817.00
210701	Гадаад албан томилолт	13,517,288.68	8,822,404.00
210702	Дотоод албан томилолт	29,262,713.00	32,340,413.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,305,650,918.41	2,375,313,481.84
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	41,023,734.00	116,812,473.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	30,000,000.00	30,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	7,065,242.00	6,549,600.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	5,354,000.00	4,367,026.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	0.00	0.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	67,907,881.00	53,196,678.00
210807	Газрын төлбөр	0.00	0.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	3,728,188.40	1,096,029.08
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	0.00	0.00
210815	Хүүний төлбөр төлсөн /ТӨҮГ/	266,513,478.08	237,494,284.48
210816	Татварын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	59,744,267.53	68,980,000.00
210817	Даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	0.00	0.00
210818	Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/	1,824,314,127.40	1,856,817,391.28
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,113,385,417.86	1,612,799,252.27
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	771,732,970.10	1,173,846,771.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	341,652,447.76	438,952,481.27
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	257,197,630.00	331,798,654.54
2132	Бусад урсгал шилжүүлэг	257,197,630.00	331,798,654.54
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	50,281,126.00	54,623,712.54
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	169,439,948.00	206,625,172.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	37,476,556.00	70,549,770.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	713,317,337.04	-446,839,562.79
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	379,862,939.00	510,336,398.99
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	379,862,939.00	510,336,398.99
2200	Дотоод эх үүсвэрээр	379,862,939.00	510,336,398.99
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	379,862,939.00	510,336,398.99
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-379,862,939.00	-510,336,398.99
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-118,757,319.00	200,000,000.00
14	Бусад эх үүсвэр	3,000,000,000.00	3,200,000,000.00
145007	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	3,000,000,000.00	3,200,000,000.00
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	3,118,757,319.00	3,000,000,000.00
250002	Зээл, өрийн үнэт цаасны төлбөр төлсөн мөнгө	3,118,757,319.00	3,000,000,000.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	214,697,079.04	-757,175,961.78
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	674,618,297.95	889,315,376.99

20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	889,315,376.99	132,139,415.21
----	--	----------------	----------------

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хөдөө аж ахуйн их сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгадагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгадагч байгууллагад бараа материалын тайланг үнэн зөв, иж бүрэн бэлтгэх, бүртгэл хөтлөлтийг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 2 дугаар сарын 15-аас 2022 оны 3 дугаар сарын 15-ны хооронд Үндэсний аудитын газрын аудитын хоёрдугаар газрын ахлах аудитор Ц.Энхжаргал, аудитор Ж.Энхтуяа нар гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер Б.Сэржмядаг, газрын захирал, Тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар хэрэгжүүлсэн.

Хөдөө аж ахуйн их сургуулийн 2021 оны санхүүгийн тайланг Үндэсний аудитын газарт 2022 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн 1/64 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хөдөө аж ахуйн их сургуулийн удирдах зөвлөлийн 2013 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаар баталсан Хөдөө аж ахуйн их сургуулийн дүрмийн 5 “...Их сургууль нь үндсэн үйл ажиллагааны хувьд ашгийн төлөө бус байгууллага бөгөөд зардлаа нөхөх санхүү, хөрөнгийн эх үүсвэр бүрдүүлэх, суралцагч, багш, ажиллагсдын ажиллах, амьдрах, орчин нөхцөл, материаллаг хангамжийг дээшлүүлэх, мэдлэгийн үйлдвэрлэл, бизнес болгох чиглэлээр холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн үйл ажиллагаа явуулна...” гэж заасан байна.

Хөдөө аж ахуйн их сургуулийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Дээд боловсролын зэрэг олгох диплом, бакалавр, магистр, докторын сургалт, мэргэжлийн болон бүрэн дунд боловсрол олгох гүнзгийрүүлсэн сургалт, мэргэшүүлэх, мэргэжил дээшлүүлэх болон богино хугацааны сургалтыг явуулах;
- Зорилтот суурь судалгаа, хавсарга шинжлэх ухааны чиглэлээр улсын хэмжээний ба салбарын урт, богино хугацааны хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэхэд оролцох, шинжлэх ухааны үндэслэлтэй санал, зөвлөмж боловсруулах;
- Олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх сургалт, судалгааны хөтөлбөр, боловсруулан хэрэгжүүлэх, гадаад харилцаа, улс хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлэх;
- ХААИС-ийн үйл ажиллагааг сурталчлах, үндэсний болон олон улсын хэмжээний үзэсгэлэн, форум, тэмцээнд оролцох;
- Багш, судлаач, суралцагчдын төлөөллийн байгууллага, төр, олон нийтийн байгууллагын төлөөлөлтэй хамтран ажиллах, дэмжлэг үзүүлэх.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Хөдөлмөрийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/
- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”;

- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 102 дугаар тушаал “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”;

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилтийг үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Хөдөө аж ахуйн их сургууль нь Боловсрол шинжлэх ухааны сайдын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 тоот тушаалаар шинэчлэн батлагдсан Боловсрол, шинжлэх ухааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагад мөрдөгдөх НБББББ-ийг мөрдөж байна.

ХААИС нь бүрэлдэхүүн 6 сургууль, эрдэм шинжилгээний 4 хүрээлэн, судалгааны 41 лаборатори, сургалт судалгааны 10 төвтэй үйл ажиллагаа явуулж байна. Тайлант онд 4 зорилт, 20 хөтөлбөр, 93 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр 90 хувьтай хэрэгжсэн байна.

Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн А/57 дугаар тушаалаар баталсан хуваарийн дагуу БШУЯ-ны Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газраас тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит, хяналт шалгалт хийх, өмч хөрөнгийн ашиглалт, бүртгэлд хяналт шинжилгээ хийж нийт 1,911.9 сая төгрөгийн 17 зөрчилд 234.7 сая төгрөгийн 2 төлбөрийн акт, 621.5 сая төгрөгийн 1 албан шаардлага, 1,055.7 сая төгрөгийн 10 зөвлөмжийг өгсөн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөдөө аж ахуйн их сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатны материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 20,712.3 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 207.1 сая төгрөгөөр тогтоосон.

Төлөвлөлтийн үе шатанд тогтоосон ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянахад өмнөх оны санхүүгийн үр дүнгийн нийт зардлаар тооцсон тул шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 22,100.5 сая төгрөгийн 1.0 хувь болох 221.0 сая төгрөгийн 70 хувь буюу 154.7 сая төгрөгөөр шинэчлэн тогтоов.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Хөдөө аж ахуйн их сургуулийн 2021 оны санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2,090.4 сая төгрөгөөр буюу 0.4 хувиар буурч, материаллаг өөрчлөлт гарсан нь мөнгөн хөрөнгө, авлага, урьдчилж гарсан зардал, үндсэн хөрөнгө, урьдчилж орсон орлого, хуримтлагдсан үр дүн данснууд байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/ Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	889.3	132.1	(757.1)
Авлага	2,119.5	1,340.0	(779.5)
Урьдчилж гарсан зардал	122.6	726.2	603.4
Бараа материал	2,453.3	2,526.9	73.5
Үндсэн хөрөнгө	45,139.6	43,909.0	(1,230.6)
Нийт хөрөнгө	50,724.5	48,634.2	(2,090.3)
Өр төлбөр	358.0	411.8	53.7
Урьдчилж орсон орлого	1,176.1	182.1	(994.0)
Өмч: - төрийн	30,693.4	30,693.4	-
Хуримтлагдсан үр дүн	3,914.7	2,764.8	(1,149.9)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	14,582.1	14,582.1	-
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	50,724.5	48,634.2	(2,090.3)

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 132.1 сая төгрөг болж, оны эхний үлдэгдлээс 757.1 сая төгрөгөөр буурсан нь ковид-19 цар тахалтай холбоотойгоор оюутны элсэлт эрс багасаж, тус сургуулийн үндсэн үйл ажиллагааны орлого буурснаас шалтгаалсан.
- Авлага данс үлдэгдэл 1,340.0 сая төгрөг болж, 779.5 сая төгрөгөөр буурсан нь эчнээ, нэмэлт сургалтын төлбөрийн авлагыг 49.4 сая төгрөгөөр, байгууллагаас авах авлагыг 669.5 сая төгрөгөөр, тус сургуулийн дансанд бүртгэлтэй байсан орон сууцыг төлбөрийн нөхцөлтэй гэрээгээр худалдан авсан 3 ажилтнаас авах авлагыг 60.4 сая төгрөгөөр тус тус барагдуулсантай холбоотой байна.
Хувь хүнээс авах 467.5 сая төгрөгийн авлагыг барагдуулахаар хууль хяналтын байгууллагад 2017, 2018, 2019 онуудад хандсан боловч Нийслэлийн Хан-Уул дүүргийн Прокурорын газраас 2018 оны 368 дугаар тогтоолоор хэрэг бүртгэлийг нээхээс татгалзаж, Нийслэлийн Хан-Уул дүүргийн Прокурорын газрын 2019 оны 816 дугаар тогтоолоор хэргийг гэмт хэргийн шинжгүй гэж үзэн тус авлагыг хэрэгсэхгүй болгох шийдвэр гаргасан байна.
- Урьдчилж гарсан зардал дансны үлдэгдэл 726.2 сая төгрөг болж, 603.5 сая төгрөгөөр өссөн нь төсөл хөтөлбөрүүдийн урьдчилж гарсан зардал 614.2 сая төгрөг, бараа материал урьдчилж бэлтгэх зардал 71.0 сая төгрөг, цалингийн урьдчилгаа 36.0 сая төгрөг, томилолтын урьдчилгаа 4.9 сая төгрөгийг тус тус олгосонтой холбоотой байна.
- Урьдчилж орсон орлого дансны үлдэгдэл 182.1 сая төгрөг болж, 994.0 сая төгрөгөөр буурсан нь нь сургалтын төлбөрийг урьдчилж төлүүлдэг байсныг, хичээлийн жилтэй уялдуулан улирлаар хуваарь гарган хэсэгчлэн төлүүлснээс шалтгаалсан байна.
- Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 43,909.0 сая төгрөг болж, 1,230.6 сая төгрөгөөр буурсан нь тайлант онд байгуулсан элэгдлийн зардлаас шалтгаалсан байна.
- Хуримтлагдсан үр дүн данс 1,149.9 сая төгрөгөөр буурсан нь тайлант онд алдагдалтай ажилласантай холбоотой байна;

3.6 Зорилтот түвшний төлөвлөлт, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 1.3-д заасны дагуу Хөдөө аж ахуйн их сургуулийн ерөнхий захирал нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

3.6.1 Зорилтот түвшний төлөвлөлт

Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны Сайдын 2020 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн А/25 дугаар тогтоолоор Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн томилсноос хойш дахин өөрчлөлт ороогүй байна.

ХААИС-ийн удирдах зөвлөл нь 2020 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор 2021 оны нийт орлогыг 17,151.2 сая төгрөг, нийт зардлыг 17,151.2 сая төгрөгөөр баталсан байна.

Тус сургуулийн удирдах зөвлөл нь 2020 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор санхүүжих эх үүсвэрийг, сургалтын төлбөрийн орлогоос 13,794.5 сая төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 926.7 сая төгрөг, бүрэлдэхүүн сургуулиудын орлогоос 1,230.0 сая төгрөг, төсөл хөтөлбөрөөс орох орлогоос 1,200.0 сая төгрөг нийт 17,151.2 сая төгрөгийн орлогыг, сургалттай холбоотой шууд зардал 14,643.2 сая төгрөг, сургалттай холбоотой шууд бус зардал 2,007.9 сая төгрөг, хөрөнгө оруулалтын зардалд 500.0 сая төгрөг нийт 17,151.2 сая төгрөгийн зардлыг тооцон төлөвлөжээ.

3.6.2 Зорилтот түвшний гүйцэтгэл

Гүйцэтгэлээр сургалтын төлбөрийн орлого 13,030.7 сая төгрөг, үндсэн бус үйл ажиллагааны орлого 2,469.3 сая төгрөг, төсөл хөтөлбөрийн орлого 2,110.3 сая төгрөг, Боловсролын зээлийн сангаас 1,588.5 сая төгрөг нийт 19,198.8 сая төгрөгийн орлого бүрдүүлжээ.

Төлөвлөснөөс нийт орлого 2,047.6 сая төгрөгөөр буюу 11.9 хувиар давж биелсэн нь төсөл хөтөлбөрийн орлого 813.5 сая төгрөг, үндсэн бус үйл ажиллагааны орлого 622.5 сая төгрөг, сургалтын төлбөрийн орлого 611.6 сая төгрөгөөр нэмэгдэж орсноос шалтгаалсан байна.

Тайлант онд нийт 20,156.0 сая төгрөг зарцуулсан нь төлөвлөснөөс 3,004.8 сая төгрөг буюу 15 хувиар хэтрүүлэн зарцуулжээ.

Нийт зардлын 13,283.3 сая төгрөг буюу 66 хувь нь цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал, ажил олгогчоос төлж байгаа нийгмийн даатгалын шимтгэлийн зардал эзэлж байна. Тогтмол зардал 986.9 сая төгрөг буюу 0.05 хувь, бараа үйлчилгээний бусад зардал 5,447.3 сая төгрөг буюу 27 хувь, хөрөнгө бэлтгэх зардал 438.3 сая төгрөг буюу 0.02 хувь, бусад зардал 6.48 хувь буюу 1,306.1 сая төгрөг байна.

Хүснэгт 2. 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин

/сая төгрөг/

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2020 оны гүйцэтгэл	2021 оны		Зөрүү	Хувь
				төлөвлөгөө	Гүйцэтгэл		
Үйлдвэрийн үндсэн үзүүлэлт							
А	Бакалаврын оюутан /тоогоор/	Тоо	5,586.0	4,646.0	5,024.0	378.0	108.1
	Магистр,докторын оюутан /тоогоор/	Тоо	440.0	400.0	401.0	1.0	100.3
Б	НИЙТ ОРЛОГО	сая/төг	21,937.6	17,151.2	19,198.8	2,047.6	111.9
	Сургалтын төлбөрийн орлого	сая/төг	13,425.1	13,425.1	14,019.2	594.1	104.4

	Магистр, докторын орлого	сая/төг	685.0	582.5	600.0	17.5	103.0
	Үндсэн бус үйл ажиллагааны орлого	сая/төг	4,852.2	1,943.6	2,566.1	622.5	132.0
	Төсөл хөтөлбөрийн орлого	сая/төг	2,139.8	1,200.0	2,013.5	813.5	167.8
	Засгийн газрын буцалтгүй тусламжийн орлого	сая/төг	835.5	0.0	0.0	0.0	0.0
В	НИЙТ ЗАРДАЛ	сая/төг	20,715.4	17,151.2	20,156.0	3,004.8	115.0
	Сургалттай холбоотой зардал	сая/төг	14,452.5	14,643.2	15,727.7	1,084.5	107.4
	Сургалтын шууд бус зардал	сая/төг	6,259.9	2,008.0	3,990.0	1,982.0	198.7
Г	Хөрөнгө оруулалттай холбоотой зардал	сая/төг		500.0	438.3	-61.7	87.7
	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	сая/төг	3.0	0.0		0.0	0.0
Д	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	сая/төг	1,222.2	0.0	-958.7	-958.7	0.0
	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	сая/төг	-4.9	0.0		0.0	
	Хэтрэлт хэмнэлт	сая/төг	1,222.2	0.0		0.0	

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тус сургуулийн суралцагчдын тоо жил бүр буурч байгаатай холбогдуулан тэвчиж болох зардлуудыг хэмнэх, дуусаагүй барилга байгууламжийн удаашралтай байгаа ажлыг эрчимжүүлэх нь тус байгууллагад тулгамдаж байгаа асуудал юм. Үүнд:

Тус сургуулийн сургалтын төлбөрийн дундаж ханш 2.7 сая төгрөг байгаа ч элсэн суралцах оюутны тоо хангалтгүй байна. Тухайлбал: Мал аж ахуй био технологийн сургуулийн бараа, түүхий эд судлал-технологи болон мал аж ахуйн-биотехнологийн 2,3 дугаар дамжаа, морин спортын менежерийн 1,2 дугаар дамжаа, загас үржүүлгийн технологийн 2,3,4 дүгээр дамжаа, тусгай хамгаалалттай газар нутаг, зэрлэг ан амьтны менежментийн 2,3,4 дүгээр дамжаа, Инженер технологийн сургуулийн металл судлал, технологийн 1,2,3 дугаар дамжаа, Агро экологийн сургуулийн газар тариалангийн аж ахуйн 1,2,3 дугаар дамжаа, хөрс судлал агро химийн 2,3,4 дүгээр дамжаа, Эдийн засаг, бизнесийн сургуулийн цахим худалдаа маркетингийн 3,4 дүгээр дамжаа, дата аналитикийн 2,3,4 дүгээр дамжаа гэсэн мэргэжлийн анги огт элсэн суралцагчгүй байгаа нь тус сургуулийн орлого бүрдүүлэхэд ихээхэн сөрөг нөлөө үзүүлж байна.

БНСУ-ын Хөдөөгийн Хөгжлийн Корпорац /KRC/ болон Хүнс хөдөө аж ахуйн яам /MAFRA/ -ны буцалтгүй тусламжаар 2019-2023 онуудад хэрэгжүүлэхээр “Монгол Улсын мал эмнэлгийн чадавхыг бэхжүүлэх, мал амьтны эрүүл мэндийн төв байгуулах” төслийн хүрээнд нийт 4 сая ам.долларын төсөвт өртөгтэй 1432 м.кв зоорины давхар бүхий 3 давхар жижиг мал амьтадын эмнэлгийн барилга, Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа 6.7 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй хичээлийн 2 дугаар байрны 9 давхар барилгын ажил, Эдийн засаг, бизнесийн сургуулийн төгсөгчдийн хандиваар баригдаж байгаа номын сангийн өргөтгөлийн барилгын ажлууд удаашралтай байна.

3.8 Аудитын гол асуудал

Тус сургууль ХААН банканд төсөл хөтөлбөр, хандив, салбар сургуулиудын ажил гүйлгээний нийт 16 данс, Худалдаа хөгжлийн банканд судалгааны төвийн 1 данс, Голомт банканд бизнес хамтын ажиллагааны хэлтсийн 3 данс нийт арилжааны банканд

байршуулсан 20 дансаар ажил гүйлгээ хийж байгаа боловч тус байгууллагын мөнгөн хөрөнгийн харилцах данснуудын хадгалалт, хамгаалалт найдвартай байдлыг банканд тавигдах шаардлагын дагуу Монгол банкнаас тогтоосон журмын заавал байлгах нөөц, төлбөр түргэн гүйцэтгэх чадвар, зохих хэмжээ, хэлбэрээр хангахын зэрэгцээ, харилцагчийн мөнгөн хөрөнгийг бүрэн байлгаж, тэдгээрийг анхны шаардлагаар гаргаж өгөх, шилжүүлэх зэрэг шаардлагын дагуу арилжааны банкны сонгон шалгаруулалт явуулаагүй, төлбөр тооцооны бүх төрлийн үйлчилгээг банктай байгуулсан гэрээний үндсэн дээр үзүүлэх байтал холбогдох гэрээ байгуулаагүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 1440 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 965 мэдээллийг хугацаа хоцроон мэдээлсэн байна.Үүнд:

- Агро экологийн сургууль 240 мэдээлэл байршуулахаас 228 мэдээлэл;
- Суурь боловсролын төв 240 мэдээлэл байршуулахаас 216 мэдээлэл;
- Инженер технологийн сургууль 240 мэдээлэл байршуулахаас 228 мэдээлэл;
- Эдийн засаг бизнесийн сургууль 240 мэдээлэл байршуулахаас 29 мэдээлэл;
- Мал аж ахуй био технологийн сургууль 240 мэдээлэл байршуулахаас 132 мэдээлэл;
- Мал эмнэлгийн сургууль 240 мэдээлэл байршуулахаас 132 мэдээллийг тус тус хугацаа хоцроож мэдээлсэн.

Харьяа салбар сургуулиуд өмнөх оны аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д “Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална” 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.3-д “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаанд нь иж бүрэн байршуулах, Шилэн дансны тухай хуулийг мөрдөж ажиллах, хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэв.

3.10 Завсрын аудитын үр дүн, Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн нийт 3 албан шаардлага, 2 зөвлөмжийг үнэлэхэд албан шаардлага 76.5 хувийн, зөвлөмж 100.0 хувийн хэрэгжилттэй байна.

Хүснэгт-4 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/сая төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	3	176.4	3	109.0	1	67.4	76.5
Зөвлөмж	2	36.5	2	36.5			100.0
Нийт дүн	5	212.9	5	145.5		67.4	88.2

Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хуулиар тогтоосон хугацаанд тогтмол, шуурхай мэдээлж байх өмнөх оны аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тус байгууллагын салбар сургуулиудын үндсэн хөрөнгийн бүртгэл, ашиглалт, хамгаалалт, тайлагналт, гадаад, дотоодын төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийг дараагийн аудитаар анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 711.7 сая төгрөгийн 8 алдаа зөрчил илэрснээс, аудитын явцад 31.4 сая төгрөгийн 4 алдааг залруулж, 680.3 сая төгрөгийн 3 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 1 алдаа зөрчилд зөвлөмж өглөө.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- Сургалтын орлого 1.4 сая төгрөгийг дутуу бүртгэсэн. (Захиргаа 1.4 сая төгрөг);
- Худалдан авсан 11.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг тодруулга тайланд тусгаагүй. (Агро экологийн сургууль 7.8 сая төгрөг, Суурь боловсролын төв 3.6 сая төгрөг)
- Үнэ төлбөргүй хүлээн авсан 6.5 сая төгрөгийн бараа материалыг санхүүгийн үр дүнгийн тайланд дутуу тусгасан. (Захиргаа 0.6 сая төгрөг, Мал эмнэлгийн сургууль 5.8 сая төгрөг)
- Түлш шатахууны 13.5 сая төгрөгийн тайлан гаргаагүй. (Захиргаа 4.3 сая төгрөг, Агро экологийн сургууль 3.7 сая төгрөг, Инженер технологийн сургууль 1.9 сая төгрөг, Эдийн засаг бизнесийн сургууль 1.6 сая төгрөг, Мал аж ахуй био технологийн сургууль 0.6 сая төгрөг, Мал эмнэлгийн сургууль 1.3 сая төгрөг)

4.3 Албан шаардлага

1. Бараа материалын данстай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт

Бараа материалын дансанд 680.3 сая төгрөгийн 5 нэр төрлийн үндсэн хөрөнгө бүртгэсэн, жилийн эцсийн хөрөнгийн тооллого хийсэн боловч тооллогыг үр дүнтэй зохион байгуулаагүй. (Агро экологийн сургууль 92.4 сая төгрөг, Суурь боловсролын төв 12.0 сая төгрөг, Инженер технологийн сургууль 116.3 сая төгрөг, Эдийн засаг бизнесийн сургууль 35.9 сая төгрөг, Захиргаа аж ахуй 368.7 сая төгрөг, Мал аж ахуй био технологийн сургууль 20.9 сая төгрөг, Мал эмнэлгийн сургууль 34.1 сая төгрөг).

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйл. Тооллогын комисс, түүний эрх,үүргийн 4.1/ эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд

үнэн зөв, чанартай явуулж дуусгах, 73 дугаар зүйлийн Эд хөрөнгийн тооллого явуулах журмын 2. “Байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулган шалгана”, Сангийн сайдын баталсан 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан Аж ахуй нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх зааврын 2 дугаар бүлэг Санхүүгийн байдлын тайлангийн 1.Үндсэн хөрөнгийн ангиллын (в) Машин, тоног төхөөрөмж: “Үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалттай бүх төрлийн машин механизмаас гадна дамжуулах төхөөрөмж, нэмэгдэл төхөөрөмжүүд”; (д)Тавилга, эд хогшил: “Нэг жилээс дээш хугацаанд ашиглагдах тавилга, аж ахуйн эд хогшил, багаж хэрэгслүүд”; (е)”Компьютер, бусад хэрэгсэл: Компьютер, хэвлэх, хувилах төхөөрөмж болон бусад хэрэгслүүд”;(ё)Бусад үндсэн хөрөнгө: “Дээрх ангилалд ороогүй бусад үндсэн хөрөнгө хамаарна” гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Тооллогын үр дүнг хэлэлцэн комиссын шийдвэр гаргаж, хөрөнгийн нэмэгдсэн, хорогдсон, илүүдэл, дутагдлын тооцоог бодож санхүүгийн тайланд тусгаж байх талаар албан шаардлага өгөв.

2.Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт

Үндсэн хөрөнгөтэй холбоотой дараах зөрчил илэрсэн. Үүнд:

- Санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 6,119.4 сая төгрөгийн 4 нэр төрлийн 4,311 ширхэг үндсэн хөрөнгө бүртгэлтэй байна. Үүнд: (Агро экологийн сургууль 615.1 сая төгрөг, Суурь боловсролын төв 153.4 сая төгрөг, Инженер технологийн сургууль 792.3 сая төгрөг, Эдийн засаг бизнесийн сургууль 472.6 сая төгрөг, Захиргаа аж ахуй 1,863.9 сая төгрөг, Мал аж ахуй био технологийн сургууль 1,329.4 сая төгрөг, Мал эмнэлгийн сургууль 892.7 сая төгрөг) Жилийн эцсийн хөрөнгийн тооллого хийсэн боловч тооллогын комисс шийдвэр гаргаагүй, үндсэн хөрөнгийн илүүдэл дутагдлыг тооцож бодоогүй.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйл. Тооллогын комисс, түүний эрх, үүргийн 4.1 “эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулж дуусгах”; 11 дүгээр зүйл Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын бүрэн эрхийн 8“төрийн өмчит хуулийн этгээдийн үл хөдлөх болон үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийг данснаас хасах санал, захиалгыг хянаж батлах, шинээр авах шийдвэр гаргах”; 73 дугаар зүйл. Эд хөрөнгийн тооллого явуулах журмын 2. “Байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулган шалгана” гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид ашиглагдах хөрөнгийн хугацааг тогтоож, дахин үнэлж үндсэн хөрөнгөд бүртгэх, эрх бүхий байгууллагын шийдвэрийн дагуу цаашид ашиглах боломжгүй болсон хөрөнгийг акталж, устган хөрөнгийн данснаас хасах / санхүүгийн тайланд тусгах, зөрчлийг арилгах талаар албан шаардлага өгөв.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт:

Тайлант онд худалдан авсан түлш, шатахууныг бараа материалын дансанд бүртгэлгүй, шууд зардлын дансанд бүртгэсэн, шатахуун зарцуулалтын тооцоо бодож, тайлан бэлтгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6 “*Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна*”, 20.1.1 “*нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, холбогдох бусад баримт бичиг, мэдээ, мэдээллийг тогтоосон хугацаанд шаардан гаргуулах*”; гэж заасантай тус тус нийцэхгүй, иж бүрэн ба оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж:

Худалдан авсан түлш, шатах тослох материалыг шууд зардалд бүртгэхгүй, бараа материалын тайлан бэлтгэж шатахууны тооцоог бодож зөрчлийг давтан гаргахгүй байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс									
							Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
					тоо	Дүн	тоо	Дүн	тоо	Дүн	тоо	дүн	тоо	дүн	Тоо	дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудлаар																
1	ХААИС	АХГ-2022/15/НА-СТА-ТӨА	Санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 6,119,495.0 мянган төгрөгийн 4 нэр төрлийн 4,311 ширхэг үндсэн хөрөнгө бүртгэлтэй байна. Жилийн эцсийн хөрөнгийн тооллого хийсэн боловч тооллогын комисс шийдвэр гаргаагүй, үндсэн хөрөнгийн илүүдэл дутагдлыг тооцож бодоогүй (Агро экологийн сургууль 615,074.5 мянган төгрөг, Суурь боловсролын төв153,387.7 мянган төгрөг, Инженер технологийн сургууль 792,306.6 мянган төгрөг, Эдийн засаг бизнесийн сургууль 472,623.7 мянган төгрөг, Захиргаа аж ахуй 1,863,967.3 мянган төгрөг. Мал аж ахуй	Албан шаардлага	1							1				

			био технологийн сургууль 1,329,359.1 мянган төгрөг, Мал эмнэлгийн сургууль 892,775.6 мянган төгрөг)													
2	ХААИС	АХГ-2022/15/НА-СТА-ТӨА	Бараа материалын дансанд 680,343.7 мянган төгрөгийн 5 нэр төрлийн үндсэн хөрөнгө бүртгэж, жилийн эцсийн хөрөнгийн тооллогыг үр дүнтэй зохион байгуулаагүй (Агро экологийн сургууль 92,371.4 мянган төгрөг, Суурь боловсролын төв 12,031.4 мянган төгрөг, Инженер технологийн сургууль 116,279.5 мянган төгрөг, Эдийн засаг бизнесийн сургууль-35,910.7 мянган төгрөг, Захиргаа аж ахуй-368,723.4 мянган төгрөг, Мал аж ахуй био технологийн сургууль 20,941.8 мянган төгрөг, Мал эмнэлгийн сургууль 34,085.2 мянган төгрөг);	Албан шаардлага	1	680,343.7					1	680,343.7				
3	ХААИС	АХГ-2022/15/НА-СТА-ТӨА	Тайлант онд худалдан авсан түлш, шатахууныг бараа материалын дансанд бүртгэлгүй, шууд	Зөвлөмж	1										1	

			зардлын дансанд бүртгэсэн, шатахуун зарцуулалтын тооцоо бодож, тайлан бэлтгээгүй байна.													
4	ХААИС	АХГ- 2022/15/НА- СТА-ТӨА	Сургалтын орлогыг дутуу бүртгэсэн (Захиргаа аж ахуй- 1,433.2 мянган төгрөг)	Залруулга	1	1,433.2	1	1,433.2								
5	ХААИС	АХГ- 2022/15/НА- СТА-ТӨА	Худалдан авсан үндсэн хөрөнгийг тодруулга тайланд тусгаагүй (Агро экологийн сургууль 7,800.0 мянган төгрөг, Суурь боловсролын төв- 3,650.0 мянган төгрөг)	Залруулга	1	11,450.0	1	11,450.0								
6	ХААИС	АХГ- 2022/15/НА- СТА-ТӨА	Үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материалыг Үр дүнгийн тайланд дутуу тусгасан (Захиргаа аж ахуй- 600.0 мянган төгрөг, Мал эмнэлгийн сургууль-5,882.0 мянган төгрөг)	Залруулга	1	6,482.0	1	6,482.0								
7	ХААИС	АХГ- 2022/15/НА- СТА-ТӨА	Түлш, шатахууныг бараа материалын дансанд бүртгэлгүй, шууд зардлын дансанд бүртгэсэн (Захиргаа-4,288.0 мянган төгрөг, Агро экологийн	Залруулга	1	13,497.3	1	13,497.3								

			сургууль-3,757.8 мянган төгрөг, Инженер технологийн сургууль-1,933.2 мянган төгрөг, Эдийн засаг бизнесийн сургууль-1,625.4 мянган төгрөг, Мал аж ахуй био технологийн сургууль-621.0 мянган төгрөг, Мал эмнэлгийн сургууль-1,271.8 мянган төгрөг)													
ДҮН					7	711,773.0	4	31,429.3			2	680,343.7			1	
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал																
1	ХААИС	АХГ- 2022/15/НА- СТА-ТӨА	Харьяа сургууль, салбар нэгжүүд нь шилэн дансны цахим мэдээллийн системд нийт 1440 мэдээлэл байршуулахаас 965 мэдээллийг хугацаа хоцроон байршуулж өмнөх оны аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй зөрчлийг давтан гаргасан байна. (Агро экологийн сургууль 240 өөс- 228, Суурь боловсролын төв 240 өөс-216, Инженер технологийн сургууль 240өөс- 228, Эдийн засаг бизнесийн сургууль	Албан шаардлага									1			

			240 өөс-29, Мал аж ахуй био технологийн сургууль 240 өөс- 132, Мал эмнэлгийн сургууль 240 өөс-132 мэдээллийг тус тус хугацаа хоцроосон)													
Дүн					1								1			
НИЙТ ДҮН					8	711,773.0	4	31,429.3			2	680,343.7	1		1	



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 557/А0150058
АХГ-2022/15/СТА-ТЦЗ-ТӨА

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу Хөдөө аж ахуйн их сургууль ТӨҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 4 нэр төрлийн 4,311 ширхэг 6,119,495,000 төгрөгийн үндсэн хөрөнгө бүртгэлтэй байна. Үүнд: (Агро экологийн сургууль 615,074,599.22 төгрөг, Суурь боловсролын төв 153,387,790.83 төгрөг, Инженер технологийн сургууль 792,306,662.25 төгрөг, Эдийн засаг бизнесийн сургууль 472,623,770.62 төгрөг, Захиргаа аж ахуй 1,863,967,372.06 төгрөг, Мал аж ахуй био технологийн сургууль 1,329,359,196.84 төгрөг, Мал эмнэлгийн сургууль 892,775,619.48 төгрөг) Жилийн эцсийн хөрөнгийн тооллого хийсэн боловч тооллогын комисс шийдвэр гаргаагүй, үндсэн хөрөнгийн илүүдэл дутагдлыг тооцож бодоогүй.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйл. Тооллогын комисс, түүний эрх, үүргийн 4.1 "эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулж дуусгах"; 11 дүгээр зүйл Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын бүрэн эрхийн 8 "төрийн өмчит хуулийн этгээдийн үл хөдлөх болон үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийг данснаас хасах санал, захиалгыг хянаж батлах, шинээр авах шийдвэр гаргах"; 73 дугаар зүйл. Эд хөрөнгийн тооллого явуулах журмын 2. "Байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулган шалгана" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1 заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Цаашид ашиглах хөрөнгийн хугацааг тогтоож, дахин үнэлж үндсэн хөрөнгөнд бүртгэх, холбогдох шийдвэрийн дагуу цаашид ашиглахгүй хөрөнгийг акталж, устган хөрөнгөнөөс хасаж дээрх зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөдөө аж ахуйн их сургуулийн захирал Т.Хэрүүга, ерөнхий нягтлан бодогч Г.Батцэцэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР

ЦАНАРАНЧИМЭГ
БЭСЭРЖМЯДАГ
ЖЭНХТУЯА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойрог-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

0010120596

110.10.10.20181101 Khereg\Alban Shaardlaga\2022\0315 Auditin 2 Gazar-83.Docx

0010801149



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 559/А0150058
АХГ-2022/15/СТА-ТШ 3-10А

Улаанбаатар хот

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу Хөдөө аж ахуйн их сургууль ТӨҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Харьяа сургууль, салбар нэгжүүд нь шилэн дансны цахим мэдээллийн системд нийт 1440 мэдээлэл байршуулахаас 965 мэдээллийг хугацаа хоцроон байршуулж өмнөх оны аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй зөрчлийг давтан гаргасан байна. (Агро экологийн сургууль 240-өөс 228, Суурь боловсролын төв 240-өөс 216, Инженер технологийн сургууль 240-өөс 228, Эдийн засаг бизнесийн сургууль 240-өөс 29, Мал аж ахуйн био технологийн сургууль 240-өөс 132, Мал эмнэлгийн сургууль 240-өөс 132 мэдээллийг тус тус хугацаа хоцроосон)

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх"; 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх"; гэсэн заалтыг зөрчсөн.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.2 заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны мэдээллийг хугацаанд нь байршуулаагүй зөрчил гаргасан салбар сургуулийн нягтлан бодогч нарт хуульд заасны дагуу сахилгын хариуцлага тооцож, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөдөө аж ахуйн их сургуулийн захирал Т.Хэрүүга, ерөнхий нягтлан бодогч Г.Батцэцэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Б.СЭРЖМЯДАГ
Ж.ЭНХТУЯА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 558/А0150058
АХГ-2022/15/СТА-1243-70А

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу Хөдөө аж ахуйн их сургууль ТӨҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Бараа материалын дансанд 680,343,706.34 төгрөгийн 5 нэр төрлийн үндсэн хөрөнгө бүртгэж, жилийн эцсийн хөрөнгийн тооллого хийсэн боловч тооллогыг үн дүнтэй зохион байгуулаагүй байна. (Агро экологийн сургууль 92,371,473.36 төгрөг, Суурь боловсролын төв 12,031,489.0 төгрөг, Инженер технологийн сургууль 110,279,523.82 төгрөг, Эдийн засаг бизнесийн сургууль 35,910,756.52 төгрөг, Захираа аж ахуй 368,723,394.64 төгрөг, Мал аж ахуй био технологийн сургууль 20,940,836.0 төгрөг, Мал эмнэлгийн сургууль 34,085,233.0 төгрөг)

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4.1 "эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулж дуусгах"; 73 дугаар зүйлийн 73.2 "Байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоньгийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж, дансны үлдэгдлийг тулган шалгана", Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан "Аж ахуй нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын 2 дугаар бүлгийн Санхүүгийн байдлын тайлангийн 1. Үндсэн хөрөнгийн ангиллын (в) "Машин, тоног төхөөрөмж: Үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалттай бүх төрлийн машин механизмаас гадна дамжуулах төхөөрөмж, нэмэгдэл төхөөрөмжүүд"; (д)Тавилга, эд хогшил." Нэг жилээс дээш хугацаанд ашиглагдах тавилга, аж ахуйн эд хогшил, багаж хэрэгслүүд"; (е) "Компьютер, бусад хэрэгсэл: "Компьютер, хэвлэх, хувилах төхөөрөмж болон бусад хэрэгслүүд"; (ё) "Бусад үндсэн хөрөнгө: "Дээрх ангилалд ороогүй бусад үндсэн хөрөнгө хамаарна" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", 42.1."Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын

бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно". Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Бараа материал, үндсэн хөрөнгийг зөв ангилан бүртгэж, үнэн зөв тайлагнах дээрх зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөдөө аж ахуйн их сургуулийн захирал Т.Хэрүүга, ерөнхий нягтлан бодогч Г.Батцэцэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
Б.СЭРЖМЯДАГ
Ж.ЭНХТУЯА

[illegible]

[illegible]